

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.10.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл	7
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.13.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3.	Менежментийн захидал.....	8
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1.	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2.	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3.	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4.	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ж.СОЛОНГО ТАНАА

2020.03.13 № 06/834
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Монгол кино нэгтгэл ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ж.Солонго Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, шинэчилсэн анхан шатын маягтын загварыг мөрдөх, үндсэн хөрөнгийг данснаас хасах тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын захирал санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 03 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөж, тус компанийн ерөнхий захирал Ц.Сугармаа, аудитор Г.Эрдэнэчимэг, аудиторовын туслах Э.Сайнзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг тус компанид 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 8 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Уран сайхны болон баримтат кино бүтээж түүгээр дамжуулан Монгол орны түүх, өв уламжлал, ёс заншил, үндэсний бахархалыг хойч үедээ амьд дуу, дүрсээр өвлүүлэх” гэж тодорхойлжээ.

Дээрх зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тодорхойлж ажиллаж байна. Үүнд:

- Уран сайхны болон баримтат кино бүтээх
- Уран бүтээлийн байгууллага хувь хүмүүст киноны мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх
- Киноны зориулалтын студи, техникээр үйлчилгээ үзүүлэх

Монгол кино нэгтгэл ТӨҮГ улсын захиалга болон өөрийн хөрөнгөөр уран сайхны болон баримтат кино бүтээх, өөрийн аппарат техник, хувцас жижиг хэрэглэлээр уран бүтээлийн байгууллага, хувь хүмүүст үйлчилгээ үзүүлэх, дуу хөгжим чимээ оруулах, Монголын киног гадаад оронд сурталчлах, гадаад болон дотоодод кино өдөрлөгүүдийг зохион байгуулах, төсвийн хөрөнгөөр бүтээгдсэн уран сайхны болон баримтат кинонуудыг эзэмшүүлэх харилцааг зохицуулах үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 466.3 сая төгрөгөөс тооцон 4.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшний тооцоололд өөрчлөлт ороогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 119.8 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	180.7	187.2	6.5
Авлага	51.2	32.5	(18.7)
Бараа материал	268.4	525.9	257.5
Үндсэн хөрөнгө	4,079.3	3,953.9	(125.5)
Нийт хөрөнгө	4,579.6	4,699.4	119.8
Өр төлбөр	4.0	12.9	8.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	124.7	124.7	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,878.3	3,878.3	-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	572.6	683.5	110.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,579.6	4,699.4	119.8

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн оны эхнээс 6.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 780.2 сая төгрөгийн мөнгөн орлого олж, 773.7 сая төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Тайлант жилд авлага 18.7 сая төгрөгөөр буурч, нийт авлагын 9.2 сая төгрөгийн 19 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд өрөө түрээслүүлснээс 2009 оноос үүссэн, 70.8 хувь буюу 22.4 сая төгрөг нь бусад авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхнээс 257.5 сая төгрөгөөр өссөн нь 2019 онд Халх голын байлдааны ялалтын 80 жилийн ойд зориулан бүтээсэн “Бууны сумыг буцааж болдоггүй” уран сайхны кинонд гарсан зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд нэмж хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 125.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант жилд ТӨБЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 587 дугаар тогтоолоор 30.2 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж худалдан авч, хөрөнгийн элэгдлийг 155.7 сая төгрөгөөр байгуулжээ.

Тайланд онд биет бус хөрөнгийн үлдэгдэл өөрчлөлтгүй байна. Өр төлбөр дансны үлдэгдэл оны эхнээс 8.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант жилд аж ахуйн нэгжийн албан татвар тооцож, түүнийг төлөөгүйтэй холбоотой байна. Хуримтлагдсан ашиг тайлант жилийн үр дүнгээр 110.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 587 дугаар тогтоолоор баталсан 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр нийт орлогыг 395.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 713.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөөг 180.6 хувиар биелүүлжээ.

2019 оны баталсан зорилтот түвшингээр 1,8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөснөөс тайлант жилд 713.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 602.4 сая төгрөгийг зарцуулж, нийт 111.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж ашгийн төлөвлөгөөг 109.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2.9. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл тодорхойлж, 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс Нягтлан бодох бүртгэлийн программ хангамж ашиглаж, санхүүгийн тайлан гаргаагүй алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлэн 3.8 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг менежментийн захидалд тусгалаа.

Өмнөх аудитаар тус байгууллагын удирдлагад санхүүгийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг авч ашиглах талаар зөвлөмж өгсөн боловч тайлант жилд нягтлан бодох бүртгэлийн программ авсан боловч ашиглаагүй зөрчил дутагдал илэрсэн болно.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажилласан талаар хянаж үзнэ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тайлант хугацаанд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой 8, худалдан авалт түүний гүйцэтгэлтэй холбоотой 9, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн талаар 6 нийт 23 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.2 сая төгрөгийн төлбөрийн акт, нягтлан бодох бүртгэлийн программ хангамж авч, ашиглах талаар 1 зөвлөмж өгснөөс төлбөрийн актыг бүрэн барагдуулж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөв.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон тодруулга, тэмдэглэлийг холбогдох хууль, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь 33 хувь хүн, иргэдээс авсан баримтууд нь тамга тэмдэггүй, хагас, дутуу бүрдэлтэй 3.8 сая төгрөгийн баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т заасан “*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*” гэсэн заалтыг зөрчиж байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн холбогдох заавар, журмыг мөрдөөгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг мөрдөж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Анхан шатны баримтын хөтлөлттэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын мөнгөн хөрөнгийн кассын нярав нь сар бүр бэлэн мөнгөний тайлан гаргахдаа Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан бэлэн мөнгөний орлогын баримт НХМаягт МХ-1, бэлэн мөнгөний зарлагын баримт, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан НХМаягт МХ-4 зэрэг маягтуудын дагуу гаргадаггүй зөрчил илэрсэн.

3.2.2 Эрсдэл:

Батлагдсан маягыг бэлэн мөнгөний тайлан гаргаагүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор илрүүлсэн 1999 оноос ашиглаж эхэлсэн 152.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, хуримтлагдсан элэгдлээр өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй болсон 98 нэр төрлийн 221 ширхэг үндсэн хөрөнгийг цаашид ашиглах боломжгүй байна. Үүнийг акталж устгах талаар холбогдох газарт нь хандаж шийдвэрлүүлээгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгө нөөцөлсөн байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид ашиглагдахгүй болсон үндсэн хөрөнгийг данснаас хасах тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	180,684,182.67	187,181,104.62
1.1.2	Дансны авлага	13,130,753.12	9,267,829.12
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	796,556.05	770,151.08
1.1.4	Бусад авлага	37,249,343.95	22,417,589.94
1.1.6	Бараа материал	268,414,030.16	525,947,744.75
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	500,274,865.947	745,584,419.52
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Барилга	3,310,366,240.94	3,184,887,707.04
1.2.2	Биет бус хөрөнгө	768,978,372.80	768,978,372.80
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,079,344,613.74	3,953,866,079.84
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,579,619,479.69	4,699,450,499.36
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,948,692.12	198,000.00
2.1.1.3	Татварын өр	2,050,143.04	12,714,362.40
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,998,835.16	12,912,362.40
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2.20	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	124,660,692.93	124,660,692.93
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,878,331,806.60	3,878,331,806.60
2.3.9	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	572,628,145.00	683,545,637.43
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	4,575,620,644.54	4,686,538,136.96
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,579,619,479.69	4,699,450,499.36

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл
1	Боруулалтын орлого (цэвэр)	268,609,706.36	466,394,462.81
2	Борлуулалтын өртөг		46,445,925.82
3	Нийт ашиг /алдагдал/	268,609,706.36	419,948,536.99
4	Түрээсийн орлого	48,692,562.73	205,393,372.73
5	Хүүний орлого	3,116,281.25	5,218,192.75
8	Бусад орлого	27,807,229.09	36,414,903.64
10	Ерөнхий ба удирдлагын зардал	339,329,031.70	528,953,024.20
12	Бусад зардал	7,997,820.31	14,688,418.61
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	23,611.74	9,913.46
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	922,539.16	123,343,476.76
19	Орлогын татварын зардал	311,628.13	12,334,347.68
20	Татварын дараах ашиг (алдагдал)	610,911.04	111,009,129.09
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	610,911.04	111,009,129.09
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	610,911.04	111,009,129.09

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	124,660,692.93	1,113,428,054.76	-	571,998,483.48	1,810,087,231.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				18,750.48	18,750.48
Залруулсан үлдэгдэл	124,660,692.93	1,113,428,054.76	-	572,017,233.96	1,810,105,981.65
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				610,911.04	610,911.04
Өмчид гарсан өөрчлөлт		2,764,903,751.84			2,764,903,751.84
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	124,660,692.93	3,878,331,806.60	-	572,628,145.00	4,575,620,644.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	124,660,692.93	3,878,331,806.60	-	572,628,145.00	4,575,620,644.54
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				111,009,129.09	111,009,129.09
Зарласан ногдол ашиг				(91,636.66)	(91,636.66)
2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	124,660,692.93	3,878,331,806.60	-	683,545,637.43	4,686,538,136.96

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	370,764,624.25	780,205,129.84
1.2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	365,633,099.00	774,986,937.09
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,015,244.00	
	Бусад мөнгөн орлого	3,116,281.25	5,218,192.75
	Мөнгөн зарлагын дүн (-)	351,718,930.74	739,805,380.14
1.3	Ажиллагчдад төлсөн	127,199,823.00	129,456,630.60
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	36,064,000.00	40,500,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	55,974,801.41	284,990,074.55
	Ашиглалтын зардалд төлсөн	85,529,352.02	175,635,194.83
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,949,854.36	
	Татварын байгууллагад төлсөн	36,141,281.77	95,325,615.89
	Бусад мөнгөн зарлага	1,859,818.18	13,897,864.27
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	19,045,693.51	40,399,749.70
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,120,207.00	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,120,207.00	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	42,928,951.00	33,821,104.55
2.3	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	31,785,800.00	30,146,104.55
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	11,143,151.00	3,675,000.00
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(41,808,744.00)	(33,821,104.55)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	91,636.66
	Төлсөн ногдол ашиг		91,636.66
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(91,636.66)
4	Гадаад валютын ханшийн зөрүү	23,611.74	9,913.46
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(22,739,438.75)	6,496,921.95
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	203,423,621.42	180,684,182.67
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	180,684,182.67	187,181,104.62

4.5. Аудит хийсэн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Кино уран бүтээл	бүлэг	32.0	32.0	-	100.0
Түүхийн хүрд	бүлэг	12.0	12.0	-	100.0
Баримтат кино	бүлэг	10.0	10.0	-	100.0
Уран сайхны кино	бүлэг	10.0	10.0	-	100.0
Нийт орлого	мян.төг	395,000.0	713,420.9	318,420.9	180.6
Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	395,000.0	713,421.0	318,421.0	180.6
Улсын төсвөөр гүйцэтгэсэн ажил	мян.төг	110,000.0	414,400.0	304,400.0	376.7
Нийт зардал	мян.төг	393,000.0	590,087.4	197,087.4	150.1
Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	93,280.0	106,571.7	13,291.7	114.2
Нийт ашиг	мян.төг	2,000.0	123,333.5	121,333.5	6,166.7
Цэвэр ашиг	мян.төг	1,800.0	111,009.2	109,209.2	6,167.1
Төсвийн төлбөрт		97,277.2	185,229.3	87,952.1	190.4
НӨАТ-д		22,300.0	44,582.7	22,282.7	199.9
НДШ-д		36,300.0	40,500.0	4,200.0	111.6
ААНОАТ-д		550.0	-	(550.0)	-
ХХОАТ-д		16,700.0	35,678.4	18,978.4	213.6
Бусад төлбөр хураамж		21,427.2	64,468.2	43,041.0	300.9
Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	-	91.6	91.6	100.0
Хөрөнгө оруулалт, их засвар	мян.төг	53,317.0	30,221.7	(23,095.3)	56.7
Нийт авлага	мян.төг	40,000.0	32,455.5	(7,544.5)	81.1
Нийт өглөг	мян.төг	2,500.0	12,714.3	10,214.3	508.6
Борлуулалтын нэг төгрөгт ноогдох зардал	төг	1.0	0.8	(0.2)	83.1
Ажиллагсадын тоо	хүн	25.0	21.0	(4.0)	84.0
Цалингийн сан	мян.төг	199,584.0	172,942.9	(26,641.1)	86.7
Дундаж цалин	мян.төг	665.3	686.3	21.0	103.2

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн	Аудитын код:
2020			САГ-2020/16/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол кино нэгтгэл ТӨҮГ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог, нэр
	1	2	3	4	5
1	Тус байгууллага нь 33 хувь хүн, иргэдээс авсан тамга тэмдэггүй, хагас дутуу бүрдэлтэй 3,8 сая төгрөгийн баримтуудыг үндэслэн мөнгөн гүйлгээний зарцуулалт хийж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т заасан “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгэээ бүртгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчиж байна.	3.8	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Солонго, Г.Төрбат
2	Тус байгууллагын мөнгөн хөрөнгийн кассын нярав нь сар бүр бэлэн мөнгөний тайлан гаргахдаа Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан бэлэн мөнгөний орлогын баримт НХМаягт МХ-1, бэлэн мөнгөний зарлагын баримт, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан НХМаягт МХ-4 зэрэг маягтуудын дагуу гаргаагүй зөрчил илэрсэн.	0.0	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Солонго, Г.Төрбат
3	Тус байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор илрүүлсэн 1999 оноос ашиглаж эхэлсэн 152.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, хуримтлагдсан элэгдлээр өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй болсон 98 нэр төрлийн 221 ширхэг үндсэн хөрөнгийг цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгүүд байна. Үүнийг акталж устгах буюу дахин хэрэглэгдэх хөрөнгө байвал үнэлж борлуулах арга хэмжээ авах	0.0	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Солонго, Г.Төрбат
4	Өмнөх аудитаар тус байгууллагын удирдлагад санхүүгийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг авч ашиглах талаар зөвлөмж өгсөн боловч тайлант жилд нягтлан бодох бүртгэлийн программ авсан боловч ашиглаагүй зөрчил дутагдал илэрсэн болно.	0.0	Албан шаардлага хүргүүлэх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Солонго, Г.Төрбат
	Нийт	3.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 16

№ 02/116

Улаанбаатар хот

САГ- 2020/16/СТА-ТӨҮГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар тус байгууллагын удирдлагад өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг авч ашиглах талаар зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн дагуу “Санхүүгийн Лидер 3.0” программ авсан боловч тайлант жилийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх болон нягтлан бодох бүртгэлдээ түүнийг огт ашиглаагүй зөрчил дутагдал илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д: “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 18.1-д: “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх болон нягтлан бодох бүртгэлдээ санхүүгийн программ ашиглан санхүүгийн тайлан гаргаж байх арга хэмжээ авч, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг захирал Ж.Солонго, ерөнхий нягтлан бодогч Г.Төрбат нарт даалгав.
2. Дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байхад анхаарч холбогдох арга хэмжээ авч ажиллах.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:
САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР
Д.ЦЭРЭНДОРЖ
“ТЭД-АУДИТ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Ц.СУГАРМАА

ЗӨВШӨӨРСӨН:
УЛААНБААТАР
МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ
Ж.СОЛОНГО
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
Г.ТӨРБАТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

